



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ
ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/15-ШТА-НА

Архангай аймаг 2024 он



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 77332860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудитор Л.Соёлмөнх
Утас: 99051561 Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Аудитор В.Цогжаргал
Утас: 99158257 Цахим хаяг: Tsogjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу.



Тайлан бэлтгэсэн: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	➤ Товчилсон үгийн тайлбар 3 ➤ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4 ➤ Үндсэн мэдээлэл 5 ➤ Аудитын тайлан 6-14
Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Аудитын менежер Д.Нэргүйбаатар Аудитор Л.Соёлмөнх, В.Цогжаргал 2024 оны 11 дүгээр сар Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү. Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033- 3141 дугаарын факсаар харилцана уу Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот	БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВӨӨС АРХАНГАЙ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНД ХУВААРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛСАН БАЙНА 1.1 АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО СУМДАД 20,250.0 МЯНГАН ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТИЙГ БУУРУУЛАН ХУВААРИЛСАН БАЙНА.....6-9 1.2 СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ ХУВААРИЛСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.....9-10 БҮЛЭГ 2. АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДЛААС 62,104.3 МЯНГАН ТӨГРӨГИЙН ХЭМНЭЛТИЙГ БИЙ БОЛГОСОН БАЙНА 2.1 АЙМАГ, СУМЫН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.....10-12 2.2. АУДИТААС ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН БАЙНА.....12 2.3 АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНООС СУМДЫН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ САЙЖИРСАН БАЙНА.....12 Дүгнэлт.....13 Тайлан баталгаажуулсан тушаал..... 14



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
МТБ	Мэдээлэл технологийн баг
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СХ	Сонгуулийн хороо
СНЖ	Сонгогчийн нэрийн жагсаалт
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн сонгуулийн хороо, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан зардлын төсөв, гүйцэтгэл	5
Хүснэгт 2	СЕХ-оос хуваарилсан санхүүжилт	6
Хүснэгт 3	Аймаг сумдад хуваарилсан санхүүжилт	7
Хүснэгт 4	Төсвийн зардлын эдийн засгийн ангилал	7
Хүснэгт 5	Сумдад бууруулан хуваарилсан зардал	8
Хүснэгт 6	Орон нутгийн 2020, 2024 оны сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс баталсан төсөв, гүйцэтгэл	9
Хүснэгт 7	Аймгийн Цагдаагийн газар, УБХ-т хуваарилсан зардлын гүйцэтгэл	9
Хүснэгт 8	Сонгуулийн зардлын гүйцэтгэл	10
Хүснэгт 9	Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар харуулбал	11



Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаал, Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.
Аудитын зорилт	Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, аудитын тайланг ҮАГ болон бусад холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ.Үүнд: ✓ Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу хуваарилсан эсэх; ✓ Аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн сонгуулийн хороо, 19 сумын сонгуулийн хороо, 105 хэсгийн хороо, аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтсийг хамруулав.
Аудитын арга зүй	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт- Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт гаргав.
Аудитын шалгуур үзүүлэлт	Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: ✓ Төрийн аудитын тухай хууль ✓ Төсвийн тухай хууль; ✓ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль ✓ Сонгуулийн төв байгууллагын тухай хууль ✓ Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль ✓ МУ-ын СЕХ-ны даргын 2021.03.19-ний өдрийн А/17 дугаар тушаалаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам” ✓ Батлагдсан төсөв, төсвийн хуваарь
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд аудитор Л.Соёлмөнх, В.Цогжаргал нар хамтран гүйцэтгэв. Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024.10.10-ны өдөр эхлүүлж, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр ҮАГ болон аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэв.



Үндсэн мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор аймгийн сонгуулийн хороог байгуулжээ. Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг 25 тойрогт аймгийн 41 мандат, сумдад 423 мандаттайгаар зохион байгуулсан байна.

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад аймгийн сонгуулийн хороонд 11, мэдээлэл технологийн багт 5, 19 сумын сонгуулийн хороонд 133, хэсгийн 105 хороонд 895 гишүүн, мэдээлэл технологийн багт 131 даамал нийт 1170 албан хаагч, мөн улсын бүртгэлийн 105 итгэмжлэгдсэн ажилтан, цагдаагийн 146 алба хаагч аймгийн хэмжээнд нийт 1426 төрийн албан хаагч ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/68 дугаар тушаалаар Архангай аймгийн сонгуулийн хороонд 1,310,602.8 мянган төгрөгийн төсвийг хуваарилж, гүйцэтгэлээр 95.3 хувь буюу 1,248,498.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдсэн 62,104.3 мянган төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлжээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/136 дугаар тушаалаар Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст сонгууль зохион байгуулах зардлын төсвийг 95,875.5 мянган төгрөгийг баталсан байна. Гүйцэтгэлээр 99.9 хувь буюу 95,776.0 мянган төгрөгийг зарцуулж, 99.5 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгон УБЕГ-т буцаан төвлөрүүлжээ.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны даргын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 16/3171 дугаар албан бичгээр Архангай аймгийн Цагдаагийн газарт сонгуулийн хамгаалалтын зардлын төсөвт 49,984.0 мянган төгрөгийг хуваарилсныг гүйцэтгэлээр 100 хувь зарцуулжээ.

Хүснэгт №1. Аймгийн сонгуулийн хороо, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан зардлын төсөв, гүйцэтгэл

Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	/мянган төгрөг/ Гүйцэтгэлийн хувь
Аймгийн сонгуулийн хороо	1,310,602.8	1,248,498.5	62,104.3	95.3
Аймгийн Цагдаагийн газар	49,984.0	49,984.0	-	100.0
Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	95,875.5	95,776.0	99.5	99.9
Нийт дүн	1,456,462.3	1,394,258.5	62,203.8	98.4

Архангай аймгийн хэмжээнд аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар нэрсийн жагсаалтад бүртгэлтэй 59191 иргэн, зөөврийн хайрцгаар санал авахаар бүртгэгдсэн 835 иргэн нийт 60026 иргэн санал өгөхөөс 67.6 хувь буюу 40580 иргэн сонгуульд оролцсон нь өмнөх аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн ирцээс 0.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВӨӨС АРХАНГАЙ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНД ХУВААРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛСАН БАЙНА

1.1 АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО СУМДАД 20,250.0 МЯНГАН ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТИЙГ БУУРУУЛАН ХУВААРИЛСАН БАЙНА.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо нь даргын 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ыг мөрдлөг болгон аймгийн сонгуулийн хорооны төсвийг эдийн засгийн ангиллын дагуу нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо, сум болон хэсгийн хороо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан хуваарилж байна.

Аймгийн сонгуулийн хороонд 6 удаагийн төсвийн хуваарийн дагуу нийт 1,310,602.8 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилсан байна. Үүнд:

Хүснэгт №2 СЕХ-оос хуваарилсан санхүүжилт

			/мянган төгрөг/
№	Албан бичгийн огноо, дугаар	Мөнгөн дүн	
1	СЕХ-ний 2024.08.19-ний өдрийн 3/777 дугаар	41,814.0	
2	СЕХ-ний 2024.09.05-ны өдрийн 3/834 дугаар	151,210.0	
3	СЕХ-ний 2024.09.13-ны өдрийн 3/852 дугаар	90,680.0	
4	СЕХ-ний 2024.09.23-ний өдрийн 3/893 дугаар	13,090.4	
5	СЕХ-ний 2024.09.27-ний өдрийн 3/909 дугаар	29,300.0	
6	СЕХ-ний 2024.10.05-ний өдрийн 3/940 дугаар	984,508.4	
Дүн		1,310,602.8	

Нийт зардлын 90 хувь буюу 1,179,657.6 мянган төгрөгийг сумын сонгуулийн хороо, хэсгийн хороонд, 10 хувь буюу 130,945.2 мянган төгрөгийг аймгийн сонгуулийн хорооны үйл ажиллагаанд зарцуулахаар хуваарилжээ. Хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №3. Аймаг сумдад хуваарилсан санхүүжилт

						/мянган төгрөг/
№	Сумдын нэрс	Хэсгийн хорооны тоо	Ажилласан албан хаагчдын тоо	Хуваарилагдсан төсөв	Хувь	
1	Аймгийн сонгуулийн хороо		16	130,945.2	10.0	
2	Эрдэнэбулган	11	120	113,154.4	8.6	
3	Ихтамир	6	56	58,778.4	4.5	
4	Чулуут	5	58	59,286.8	4.5	
5	Хангай	6	56	60,077.6	4.6	
6	Тариат	7	64	67,917.2	5.2	
7	Өндөр-Улаан	5	58	59,254.8	4.5	
8	Эрдэнэмандал	6	68	69,320.8	5.3	
9	Жаргалант	5	58	59,926.8	4.6	
10	Цэцэрлэг	5	58	59,830.8	4.6	
11	Хайрхан	5	58	59,504.4	4.5	
12	Батцэнгэл	6	68	68,770.4	5.2	
13	Өлзийт	4	48	49,489.6	3.8	
14	Өгийнуур	5	58	59,114.0	4.5	
15	Хашаат	5	58	59,562.0	4.5	
16	Хотонт	6	68	68,847.2	5.3	



17	Цэнхэр	6	62	63,620.8	4.9
18	Төвшрүүлэх	4	48	49,148.0	3.8
19	Булган	4	42	44,000.8	3.4
20	Цахир	4	48	50,052.8	3.8
Аймгийн дүн		105	1170	1,310,602.8	100.0

Дээрх хүснэгтээс харахад Эрдэнэбулган сумын сонгуулийн хороо хамгийн өндөр буюу 113,154.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан бол Булган сумын сонгуулийн хороо хамгийн бага нийт санхүүжилтийн 3.4 хувь буюу 44,000.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авчээ.

Улсын төсвөөс аймгийн сонгуулийн хороонд сонгууль зохион байгуулахтай холбогдуулан олгосон санхүүжилтийн хуваарилалтыг зардлын ангиллаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 4. Төсвийн зардлын эдийн засгийн ангилал

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Улсын төсвөөс хуваарилсан	Нийт зардалд эзлэх хувь	Аймгийн СХ-оос хуваарилсан	
				Сумын СХ- нд олгосон	Аймгийн СХ-нд олгосон
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1,460.0	0.1	-	1,460.0
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	15,552.0	1.2	9,564.3	5,987.7
3	МТБ, даамлын сургалт	24,802.0	1.9	17,104.3	7,697.7
4	Бичиг хэрэг	16,450.0	1.3	15,450.0	1,000.0
5	Шуудан холбоо	20,100.0	1.5	12,400.0	7,700.0
6	Унааны зардал	85,260.0	6.5	82,910.0	2,350.0
7	Санал авах байр бэлтгэх	29,400.0	2.2	29,400.0	-
8	Сурталчилгааны зардал	20,000.0	1.5	-	20,000.0
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.0	0.1	-	1,300.0
10	Саналын хуудас, төхөөрөмжийн авах хүргэх ачаа томилолтын зардал	53,404.0	4.1	35,626.4	17,777.6
11	Томилолтын зардал	15,976.0	1.2	9,358.2	6,617.8
12	Сүлжээний судалгаа хийх зардал	1,271.0	0.1	-	1,271.0
13	Саналын хуудас устгах зардал	1,179.4	0.1	-	1,179.4
14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	10,640.0	0.8	6,680.0	3,960.0
15	Санал авах байрны түлшний зардал	11,400.0	0.9	4,760.0	6,640.0
16	Сурталчилгааны материал тараах унааны зардал	14,700.0	1.1	7,350.0	7,350.0
17	Шуурхай багийн зардал	3,200.0	0.2	-	3,200.0
18	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал	860,388.8	65.6	841,035.2	19,353.6
19	МТБ-ийн гишүүн даамлын урамшуулал, хоолны зардал	109,569.6	8.4	101,959.2	7,610.4
20	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх зардал	5,970.0	0.5	-	5,970.0
21	Болзошгүй зардал	8,580.0	0.7	6,060.0	2,520.0
НИЙТ ДҮН		1,310,602.8	100.0	1,179,657.6	130,945.2
Эзлэх хувь				90.0	10.0



Нийт зардлын 74.0 хувийг сонгуулийн хороо болон хэсгийн хороонд ажилласан албан хаагчдын урамшуулал, хоолны зардал, холбогдох татвар, НДШ-ийн зардалд, 6.5 хувийг сум болон хэсгийн хороодод ажиллах болон зөөврийн хайрцгаар санал авах унааны зардалд, 19.5 хувийг бусад зардалд хуваарилсан байна.

УИХ-ын 2024 оны сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон зардлын гүйцэтгэлд хийсэн аудитаар зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан зөрчил илэрсэнтэй холбоотойгоор СЕХ-оос хуваарилсан дараах зардлыг аймгийн сонгуулийн хороо сумдад хуваарилахдаа 20,250.0 мянган төгрөгөөр бууруулсан байна. Үүнд:

Хүснэгт №5 Сумдад бууруулан хуваарилсан зардал

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	СЕХ-ны хуваарилсан	АСХ-ны хуваарилсан	Зөрүү
1	Шуудан холбоо	18,600.0	12,400.0	6,200.0
2	Санал авах байрны түлшний зардал	11,400.0	4,700.0	6,700.0
3	Сурталчилгааны материал тараах унааны зардал	14,700.0	7,350.0	7,350.0
НИЙТ ДҮН		44,700.0	24,450.0	20,250.0

1. Шуудан холбооны зардалд 19 сум, 105 хэсгийн хороонд тус бүр 150.0 мянган төгрөгөөр тооцон нийт 18,600.0 мянган төгрөг хуваарилсныг аймгийн сонгуулийн хороо 100.0 мянган төгрөгөөр тооцож 12,400.0 мянган төгрөгийг олгож, 6,200.0 мянга;
2. Санал авах байрны түлшний зардалд 76 хэсгийн хороонд тус бүр 150.0 мянган төгрөгөөр тооцон нийт 11,400.0 мянган төгрөг хуваарилсныг аймгийн сонгуулийн хороо 94 хэсгийн хороонд тус бүр 50.0 мянган төгрөгөөр тооцож 4,700.0 мянган төгрөгийг олгож, 6,700.0 мянга;
3. Сурталчилгааны материал тараах унааны зардалд 105 хэсгийн хороонд тус бүр 140.0 мянган төгрөгөөр тооцон нийт 14,700.0 мянган төгрөг хуваарилсныг аймгийн сонгуулийн хороо хэсгийн хороонд тус бүр 70.0 мянган төгрөгөөр тооцож 7,350.0 мянган төгрөгийг олгож, 7,350.0 мянган төгрөгийг тус тус бууруулан хуваарилж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос аймаг, сумын сонгуулийн хорооны гишүүд, МТБ-ийн гишүүн даамлын урамшуулал, хоолны зардлыг хуваарилахдаа НДШ, ХАОАТ-ыг зөрүүтэй тооцсоноос 9,828.0 мянган төгрөгийг илүү хуваарилсныг аймгийн сонгуулийн хороо төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгохоор баталсан төсөв нь аймаг, сумын ИТХ-ын 2020 оны сонгуулийн зардлын төсвөөс 2.5 дахин их буюу 775,767.8 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Харьцуулсан судалгааг дэлгэрэнгүй байдлаар харуулбал:

Хүснэгт №6. Орон нутгийн 2020, 2024 оны сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс баталсан төсөв, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Орон нутгийн ээлжит сонгууль	Сонгуулийн хороо	СХ- ны тоо	ХХ- ний тоо	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
Орон нутгийн 2020 оны ээлжит сонгууль	Аймгийн сонгуулийн хороо	1		123,051.3	114,920.0	8,131.3
	Сумын сонгуулийн хороо	19	105	411,783.7	411,253.5	530.2
НИЙТ ДҮН		20	105	534,835.0	526,173.5	8,661.5



Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль	Аймгийн сонгуулийн хороо	1		130,945.2	74,057.4	56,887.8
	Сумын сонгуулийн хороо	19	105	1,179,657.6	1,174,441.2	5,216.4
Нийт дүн		20	105	1,310,602.8	1,248,498.6	62,104.2

1.2 СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ ХУВААРИЛСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/136 дугаар тушаалаар Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст сонгууль зохион байгуулах зардлын төсвийг 95,875.5 мянган төгрөгөөр, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны даргын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 16/3171 дугаар албан бичгээр Архангай аймгийн Цагдаагийн газарт сонгуулийн хамгаалалтын зардлын төсөвт 49,984.0 мянган төгрөгийг тус тус төлөвлөж хуваарилсан байна. Хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Хүснэгт №7. Аймгийн Цагдаагийн газар, УБХ-т хуваарилсан зардлын гүйцэтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Зардлын гүйцэтгэлийн дүнд эзлэх хувь
Улсын бүртгэлийн хэлтэс	УББ-ийн ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол унааны зардал	63,855.0	63,828.5	26.5	66.6
	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэхэд шаардагдах зардал	4,364.5	4,364.5	-	4.6
	Сонгогчдын нэрсийн жагсаалтыг сонгуулийн хэсгийн хороодод хүргэх зардал	2,140.0	2,129.5	10.5	2.2
	Сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардал /томилолт, унааны зардал/	16,590.0	16,528.4	61.6	17.3
	Сургалтын бусад зардал	2,090.0	2,089.0	1.0	2.2
	Сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардал	6,836.0	6,836.0	-	7.1
Дүн		95,875.5	95,775.9	99.6	100.0
Цагдаагийн газар	Эргүүл хамгаалалтын үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хоолны зардал	26,864.0	26,864.0	0.0	53.7
	Томилолтын төсөв	8,100.0	8,100.0	0.0	16.2
	Шуудан холбооны зардал	12,020.0	12,020.0	0.0	24.0
	Шатахуун	3,000.0	3,000.0	0.0	6.0
Дүн		49,984.00	49,984.00	0	100.0
Нийт дүн		145,859.50	145,759.90	99.6	-

Эх сурвалж: Аймгийн Цагдаагийн газар, УБХ-ийн сонгуулийн зардлын тайлан

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан төсвийн 66.6 хувийг сонгуульд ажилласан улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал, хоол унааны зардал



эзэлж байгаа бол аймгийн Цагдаагийн газарт хуваарилсан төсвийн 53.7 хувийг эргүүл хамгаалалтын үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хоолны зардал эзэлж байна.

БҮЛЭГ 2. АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДЛААС 62,104.3 МЯНГАН ТӨГРӨГИЙН ХЭМНЭЛТИЙГ БИЙ БОЛГОСОН БАЙНА

2.1. АЙМАГ, СУМЫН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА

СЕХ-оос Архангай аймгийн сонгуулийн хороонд 1,310,602.8 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилж, гүйцэтгэлээр 1,248,498.5 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэлтээр үлдсэн 62,104.3 мянган төгрөгийг СЕХ-нд буцаан төвлөрүүлжээ. Зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №8 Сонгуулийн зардлын гүйцэтгэл

№	Сумдын нэрс	Сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлын		Үлдэгдэл
		Төсөв	Гүйцэтгэл	
1	Ихтамир	58,778.4	58,384.1	394.3
2	Чулуут	59,286.8	59,286.8	0
3	Хангай	60,077.6	59,651.6	426.0
4	Тариат	67,917.2	67,823.7	93.5
5	Өндөр-Улаан	59,254.8	59,254.8	0
6	Эрдэнэмандал	69,320.8	69,320.8	0
7	Жаргалант	59,926.8	59,882.7	44.1
8	Цэцэрлэг	59,830.8	59,703.2	127.6
9	Хайрхан	59,504.4	59,504.4	0
10	Батцэнгэл	68,770.4	68,355.4	415
11	Өлзийт	49,489.6	49,489.6	0
12	Өгийнуур	59,114.0	58,800.8	313.2
13	Хашаат	59,562.0	56,733.3	2828.7
14	Хотонт	68,847.2	68,750.3	96.9
15	Цэнхэр	63,620.8	63,421.3	199.5
16	Төвшрүүлэх	49,148.0	49,059.6	88.44
17	Булган	44,000.8	43,987.6	13.2
18	Эрдэнэбулган	113,154.4	112,978.4	176.0
19	Цахир	50,052.8	50,052.8	0
20	Аймаг	130,945.2	74,057.4	56,887.9
Аймгийн дүн		1,310,602.8	1,248,498.5	62,104.3

Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан 6 удаагийн санхүүжилтийг зарцуулахтай холбоотой ирүүлсэн заавар чиглэлийн дагуу аймаг, сумын сонгуулийн хороо зардлыг эдийн засгийн ангилалын дагуу зарцуулжээ.

Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлсэн нийт дүнгийн 94.8 хувь буюу 56,887.9 мянган төгрөг нь аймгийн сонгуулийн хороо, 5.2 хувь буюу 5,216.4 мянган төгрөг нь 13 сумын сонгуулийн хорооны зардлаас хэмнэгдсэн байна.

Сайн жишээ: Хашаат сумын сонгуулийн хороо нь хуваарилсан төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж төсвийнхөө 5 орчим хувийг буцаан төвлөрүүлсэн нь сумын сонгуулийн хороодоос төвлөрүүлсэн хөрөнгийн 54.2 хувийг эзэлж байна.



Хүснэгт № 9. Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар харуулбал:

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1,460.0	1,460.0	0.0
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	15,552.0	15,150.3	401.7
3	МТБ,даамлын сургалт	24,802.0	22,608.3	2,193.7
4	Бичиг хэрэг	16,450.0	16,313.2	136.8
5	Шуудан холбоо	20,100.0	12,400.0	7,700.0
6	Унааны зардал	85,260.0	83,784.4	1,475.6
7	Санал авах байр бэлтгэх	29,400.0	29,062.5	337.5
8	Сурталчилгааны зардал	20,000.0	19,200.0	800.0
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.0	1,300.0	0.0
10	Саналын хуудас, төхөөрөмжийн авах хүргэх ачаа томилолтын зардал	53,404.0	50,226.4	3,177.6
11	Томилолтын зардал	15,976.0	14,174.2	1,801.8
12	Сүлжээний судалгаа хийх зардал	1,271.0	0.0	1,271.0
13	Саналын хуудас устгах зардал	1,179.4	1,179.4	0.0
14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	10,640.0	6,680.0	3,960.0
15	Санал авах байрны түлшний зардал	11,400.0	4,510.0	6,890.0
16	Сурталчилгааны материал тараах унааны зардал	14,700.0	7,000.0	7,700.0
17	Шуурхай багийн зардал	3,200.0	0.0	3,200.0
18	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	860,388.8	850,820.2	9,568.6
19	МТБ-ийн гишүүн даамлын урамшуулал, НДШ	109,569.6	108,249.7	1,319.9
20	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх зардал	5,970.0	0.0	5,970.0
21	Болзошгүй зардал	8,580.0	4,380.0	4,200.0
НИЙТ ДҮН		1,310,602.8	1,253,715.0	62,104.3

Нийт хэмнэгдсэн 62,104.3 мянган төгрөгийн дүнд СЕХ-ны илүү хуваарилсан 9,828.0 мянга, АСХ бууруулан хуваарилсан 20,250.0 мянган төгрөг байгаа бол бусад хэмнэгдсэн болон огт зарцуулагдаагүй дараах 32,026.3 мянган төгрөгийн зардлууд байна. Үүнд:

- ✓ Сонгуулийн хорооны гишүүд, МТБ,даамлын сургалт, саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх шатахууны зардлыг СЕХ сумдад тогтмол дүнгээр тооцож хуваарилсныг аймгийн сонгуулийн хороо км-р тооцож хуваарилснаас 7,574.8 мянга;
- ✓ Сонгуулийн хорооны гишүүд, МТБ,даамлын урамшууллын зардлаас тэтгэвэр тогтоолгосон болон хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчийн НДШ-ийн зөрүүнээс 1,060.6 мянга;
- ✓ Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардлыг СЕХ сумдад тогтмол дүнгээр тооцож хуваарилсныг аймгийн сонгуулийн хороо ялгаатай хуваарилснаас 3,960.0 мянга;
- ✓ Болзошгүй зардлаас аймаг болон 5 сумын сонгуулийн хороо хуваарилагдсан төсвийг зарцуулаагүй 4,200.0 мянга;
- ✓ Сүлжээний судалгааг УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлаар хийсэн тул хуваарилагдсан төсвийг зарцуулаагүй 1,271.0 мянга
- ✓ Шуурхай багийн зардал, тоног төхөөрөмжийн тохиргоо хийх зардал нь шаардлагатай тохиолдолд зарцуулахаар хуваарилагдсан боловч зарцуулаагүй 9,170 мянга



- ✓ Бусад зардлаас 4,789.9 мянган төгрөгийг тус тус хэмнэж, төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвшрүүлэх сумын Баян-Өндөр баг 1-10-2-р хэсгийн хорооны нэр дэвшигч У.Золжаргал, С.Эрдэнэцэцэг нар 175 санал авч тэнцсэн тул 2024 оны 10 -р сарын 13-ны өдөр нэмэлт санал хураалт зохион байгуулсан байна. Аймгийн сонгуулийн хорооны даргын 2024 оны 10 сарын 14-ны өдрийн 10 дугаар захирамжаар нэмэлт санал хураалт зохион байгуулахтай холбоотой 500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг сумын сонгуулийн хороонд олгож гишүүдийн хоолны зардалд зарцуулсан байна.

2.2. АУДИТААС ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН БАЙНА

СЕХ-ны даргын 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/56 дугаар захирамжаар баталсан удирдамжийн дагуу “Сонгуулийн хороонд ажиллах ажилтны арга зүй” сургалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж сумын сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Үүний үр дүнд аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан гарсан зардлын гүйцэтгэлийн тайланг СЕХ-ний даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу гүйцэтгэлийг тайлагнасан байна.

УИХ-ын 2024 оны сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитаар хүргүүлсэн эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх, холбогдох журмыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

2.3 АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНООС СУМДЫН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ САЙЖИРСАН БАЙНА

СЕХ-ний даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2-т заасны дагуу аймгийн ИТХ-ын 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Архангай аймгийн сонгуулийн хорооны даргыг, аймгийн сонгуулийн хорооны даргын захирамжаар сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодын дарга нарыг томилон төсвийг зарцуулах эрхийг нээж өгчээ.

Аймгийн сонгуулийн хорооны даргын баталсан удирдамжийн дагуу томилогдсон 3 ажлын хэсэг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 06-ний өдрүүдэд бүх сумдын сонгуулийн хороо, хэсгийн хороодын үйл ажиллагаатай газар дээр нь хяналт тавьж, зөвлөн тусалж ажилласан байна.

Салбар хороодын дарга, нарийн бичгийн дарга нар олгосон санхүүжилт бүрийг хяналттай, зориулалтын дагуу зарцуулж санхүүжилтийн тайланг архивын нэгж болгон аймгийн сонгуулийн хороонд тойрох хуудсаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлд тавих хяналт сайжирсан байна.

----- ооОоо -----



АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- ✓ Аймгийн сонгуулийн хороо сумдад 20,250.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бууруулан хуваарилсан байна.
- ✓ Сонгууль зохион байгуулахтай холбоотой аймгийн цагдаагийн газар, улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна
- ✓ Аймаг, сумын сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна
- ✓ Аудитаас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.
- ✓ Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад тавих хяналт сайжирсан байна



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/42

Эрдэнэбулган сум

Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэхийг аудитор (Л.Соёлмөнх)-д даалгасугай.

3.Аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Л.Соёлмөнх), (В.Цогжаргал) нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (Д.Нэргүйбаатар)-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

